



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 9.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсад 2025 онд зохион байгуулах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хавсралтад заасан Олимпын эрхийн оноо, дэлхийн чансаа олгох тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 2,539,000,000 (хоёр тэрбум таван зуун гучин есөн сая) төгрөгийн, Олон улс, тив, олимпын бус төрлийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 567,728,100 (таван зуун жаран долоон сая долоон зуун хорин найман мянга нэг зуу) төгрөгийн зардлыг 2025 оны батлагдсан төсвийн багцаас санхүүжүүлэхийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номинд даалгасугай.

3.Тэмцээний бэлтгэл ажлыг бүрэн ханган, өндөр түвшинд зохион байгуулж, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номинд даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ч.НОМИН

Засгийн газрын 2025 оны 05 дугаар
сарын 21-ний өдрийн 243 дугаар
тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСАД 2025 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ОЛОН УЛС, ТИВ, ДЭЛХИЙН
АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Тэмцээний нэр
1.	Олимпын эрхийн оноо, дэлхийн чансаа олгох тэмцээн
1.1.	Жүдо бөхийн “Улаанбаатар их дуулга 2025”
1.2.	Чөлөөт бөхийн “Улаанбаатар опен”
2.	Олон улс, тив, олимпын бус төрлийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн
2.1.	Снукер бильярддын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн
2.2.	Морьт харвааны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн
2.3.	Шатрын сурагчдын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн
2.4.	Уран сайхны гимнастикийн Ази тивийн цомын аварга шалгаруулах тэмцээн
2.5.	Дуатлоны Ази тивийн цомын аварга шалгаруулах тэмцээн
2.6.	Электрон спортын “Номадик Мастерс” тэмцээн
2.7.	Жюү жицүгийн “Улаанбаатар про 2025” 7 дахь удаагийн тэмцээн
2.8.	Спорт авто машины “Экстрим, энтертаймент-2025” тэмцээн
2.9.	Сонгодог дартсын “Дартс фестиваль-2025” тэмцээн

----o0o----